

Үг боловсруулагч

Бэсси үнээ уран зохиолын хичээлдээ зориулан эссэн дээр ажиллаж байна. Түүний бичгийн хэлбэр муу учраас тэрбээр эссэгээ үг боловсруулагч ашиглан бичихээр болжээ.

Эссэ нь зайгаар тусгаарлагдсан N үгнүүдээс ($1 \leq N \leq 100$) бүрдэнэ. Үг бүр нь 1-ээс 15 хүртэлх урттай том болон жижиг үсгүүдээс бүрдэх юм. Даалгаврын шаардлагын дагуу эссэ нь нэгэн хэлбэрийг дагах ёстой: мөр бүр нь хоосон зайг тооцохгүйгээр K -с ($1 \leq K \leq 80$) хэтрэхгүй урттай байна. Азаар Бэссигийн үг боловсруулагч нь дараах стратегиар дээрх асуудлыг шийдэж чадна:

- Хэрэв Бэсси үг бичихэд тухайн мөрөнд багтаж байвал тухайн мөрөнд нь бичнэ.
- Үгүй бол шинэ мөрнөөс эхэлж бичээд тэр мөрнөөсөө үргэлжлэх юм.

Мэдээж нэг мөрөнд байгаа дараалсан үгнүүд хоорондоо зайтай байх ёстой. Ямар ч мөрний төгсгөлд зай байж болохгүй.

Харамсалтай нь Бэссигийн үг боловсруулагч эвдэрчихжээ. Иймд Бэссигийн эссэг дээрх хэлбэрт оруулж туслана уу.

ОРОЛТ (файл word.in):

Эхний мөрөнд зайгаар тусгаарлагдсан N болон K тоонууд байрлана.

Дараагийн мөрөнд N үгнүүд хоосон зайгаар тусгаарлагдан өгөгдөнө. Ямар ч үгийн урт K -с буюу хамгийн их авч болох мөрний уртаас хэтрэхгүй байна.

ГАРАЛТ (файл word.out):

Бэссигийн зөв хэлбэрт орсон эссэ.

Жишээ оролт:

```
10 7
hello my name is Bessie and this is my essay
```

Жишээ гаралт:

```
hello my
name is
Bessie
and this
is my
essay
```

"hello" болон "my" үгнүүдийг агуулсан эхний мөр нь хоосон зайг оролцуулахгүйгээр 7 урттай байна. Хэрэв "name" үгийг эхний мөрөнд оролцуулсан бол хоосон зайгүй $11 > 7$ урттай болчих учраас дараагийн шинэ мөрөнд байрлуулжээ.

Зохиогч: Nathan Pinsker

Орчуулсан: Battulga Enkhbayar